



## Силикат ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны тайлан

“Силикат” ХК-ийн эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид та бүхний амар амгаланг айлтган мэндчилж байна.

### 1. Компанийн тухай тойм:

- Силикат ХК нь 1966 онд Польш улсын хөрөнгө оруулалтаар “Силикат тоосго, шохойн үйлдвэр” нэрээр Дархан хотын анхны аж үйлдвэр болон байгуулагдсан.
- 1966 оноос 1992 он хүртэл тасралтгүй ажилласан ба тухайн үеийн Монгол улсын ханын материалын хэрэгцээний 25%-ийг дангаар хангаж байсан түүхтэй.
- 2006 онд Силикат цагаан тоосгоны дамжлагыг Силикат хөнгөн блокны үйлдвэр болгон шинэчилсэн. Тэр үеэс хойш хөнгөн бетон болон шохойн үйлдвэрлэлийн чиглэлээр тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж байна.

### Силикат үйлдвэрийн бааз суурь, дэд бүтэц.

- “Силикат”ХК-ны үйлдвэрийн байр нь Дархан хотын үйлдвэрийн дүүрэгт өөрийн байранд байрладаг;
- 150 мм-н диаметртэй өндөр даралтын уурын шугамаар ДДЦС ТӨХК-тай холбогдсон;
- Төвийн дулаан, цэвэр бохир усны шугамд холбогдсон дэд бүтэц бүрэн хийгдсэн;

1. Хөнгөн бетоны үйлдвэр нь хоногт 150 м<sup>3</sup>, жилдээ 54000м<sup>3</sup> үйлдвэрлэх хүчин чадалтай.

- Түүхий эдийн үндсэн ордууд нь харьцангуй ойр оршдог нь тээврийн зардалд

хэмнэлттэй төдийгүй үйлдвэрлэлийн тогтвортой ажиллагааг хангахад чухал хүчин зүйл болдог.

- Силикат ХК нь Дархан уул аймаг, Эрдэнэт Хөвсгөл, Булган, Сэлэнгэ зэрэг төвийн бүсийн бүхий л хэрэглэгчдэд авто замаар болон төмөр замаар хөнгөн бетон блок тээвэрлэн нийлүүлж байна.



2024 онд компанийн удирдлагаас авч хэрэгжүүлсэн ажлын тайланг та бүхэнд танилцуулья.

Силикат үйлдвэрлэл:

- Блокны зүсэлтийг сайжруулсан мөн цехээс гарч байгаа бэлэн бүтээгдэхүүнийг гаднах талбайд цэгцтэй хурааж, талбайн цэвэрлэгээг тогтмолжуулсан.
- Аюулгүй ажиллагааг сайжруулсан.
- Автоклавын уур өсөлт, шаралтын хугацаа, горимын технологийг чанд мөрдөж, бэлэн бүтээгдэхүүний стандартын шаардлагыг бүрэн хангасан эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх болсон.



Үйлдвэрлэлийн дотоод орчин:

Түүхий эд материал:

Дарханы зам засвартай холбоотой цементийн хомсдол богино хугацаанд үүсэж үнэ өссөн ч буцаж тогтворжсон . Бусад түүхий эд материалын үнэ инфляцтай холбоотой өссөн.

Тоног төхөөрөм:

Силикат үйлдвэр нь сүүлийн жилүүдэд тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгээгүй учраас гар ажиллагаа их мөн элэгдэж хуучирснаас үүдэн эвдрэл гэмтэл их гарч байна. Иймд ажиллах хүчний зардал өндөр, сэлбэг хэрэгслийн олдоц муу, засварын зардал өндөр байна.

Хүний нөөц:

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа улирлын шинж чанартай явагдаж байгаа учраас ажилчдын тогтвор суурьшил муу, ажиллах хүчний хомсдол ихтэй байна. Тоног төхөөрөмжүүд ар ажиллагаа их учраас ажиллах хүчнээс шууд хамааралтай.

Тогтмол зардал:

Энэ жилээс цахилгаан, дулаан, уур усны үнэ нэмэгдэж байгаа тул үйлдвэрлэлийн хэмжээ мөн бүтээгдэхүүний үнээ ихэсгэхгүй бол алдагдалтай ажиллахад хүрээд байна.

Гадаад орчны нөлөөлөл:

Ойрын жилүүдэд шинэ хөнгөн блокны үйлдвэр олон тоогоор нэмэгдэж, бетон зуурмаг болон бусад шинэ төрлийн дүүргэгч материал ихээр зах зээлд нэвтэрч байна. Ийнхүү бид өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхийн тулд тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх шаардлагатай байна.